

# БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХЭРЭГГИЖ БУЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА

2017 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

## ***Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго***

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарын хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрүүдийн 2015 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгөв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан, мэдээллийг үндэслэн тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан тогтоож, байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэхээр заасан хяналтад авсан заалтуудын биелэлт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгч, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж гарган дэмжлэг үзүүлэх, бодит мэдээллээр хангах зорилгыг харгалзан үнэлэв.

## ***Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй***

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг удирдлага болгон, 2016 оны жилийн эцсийн байдлаар УИХ-ын тогтоолоор батлагдсан 3, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 11, нийт 14 байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хяналтад авч, гүйцэтгэлийн үр дүнг нотлох, холбогдох материал судалгааг ашиглан, асуудал хариуцсан нэгж, мэргэжилтнээс тайлбар, нэмэлт тодруулга авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулж бататган, хэрэгжилтийн тайлан, мэдээллийг үндэслэн удирдлага, зохион байгуулалтын болон оролцогч талуудын хамтын ажиллагаа зэргийг харгалзан үнэлэв.

## ***Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн***

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлэх 2016 оны жилийн эцсийн байдлаар УИХ-ын тогтоолоор батлагдсан 3, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 11, нийт 14 үндэсний хөтөлбөрийг хяналтад авч, хэрэгжилтийн гүйцэтгэлд үнэлгээ өгөв.

2016 оны жилийн эцсийн байдлаар ерөнхий гүйцэтгэл **76.8 хувьтай** буюу **3.84 оноотой дүгнэгдэж**, 1 хөтөлбөр 100% буюу бүрэн хэрэгжсэн, 5 хөтөлбөр 90 хувьтай, 5 хөтөлбөр 70 хувьтай, 2 хөтөлбөр 50 хувийн биелэлттэй, 1 хөтөлбөр үнэлэх боломжгүй буюу үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулахад **0.8 хувийн өсөлттэй** дүгнэгдэв. Үнэлгээний дүнг хавсралт 1-д харуулав.

## ***Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, хэрэгжүүлсэн арга хэмжээ***

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хэрэгжүүлэх 14 үндэсний хөтөлбөрийн хүрээнд дор дурьдсан үр дүн гарсныг дараах байдлаар хөтөлбөр тус бүрээр томъёолов. Үүнд:

### **1. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**

Хөтөлбөрийн 2 дахь үе шатны хэрэгжилтийн хугацаа дуусч байгааг нэгтгэн дүгнэхэд, дараах ололт, үр дүн гарав. Үүнд:

1. Тогтвортой хөгжлийн талаарх төрийн бодлогын зорилтууд хэрэгжиж, үр дүнгээ өгч эхэлсэн.

2. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр /УИХ,1988/ 3.4-т “Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт улсын нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ”, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /УИХ,2010/, Ногоон хөгжлийн бодлого /УИХ,2014/ 3.2.1-т “Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах”, Монгол Улсын тогтвортой

хөгжлийн үзэл баримтлал-2030 /УИХ,2 016/ “Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /УИХ, 2016/-ийн “Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авна.” хэмээн тодорхойлсон төрийн бодлого зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор газар нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулахаар судалгаа хийж, үндэслэлийг боловсруулав. Түүнчлэн 7 аймгийн 12 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 4 өргөтгөл, 2 байгалийн нөөц газар, 1 дурсгалт газрыг улсын тусгай хамгаалалтад авснаар талбайн хэмжээ 1 840 267.59 га-аар буюу нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь 1.18 хувиар нэмэгдэж, 29039667.59 га болсноор улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нийтдээ 18.5 хувийг эзлэх болно.

### 3. Хамарсан экосистем:

- Улсын хэмжээнд 12.4 сая га талбай бүхий 20 дархан цаазат газар, 11.7 сая га талбай бүхий 32 байгалийн цогцолборт газрууд нь байгалийн үндсэн бүс, бүслүүрийн унаган төрхийг хадгалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад голлох үүрэг гүйцэтгэж байна.

- Монгол орны өндөр уулын 11,1-40,7%, ойн 9,9-31,1%, хээрийн 4,2-7,6%, ус, намгархаг газрын 13,9-79,0%, говь цөлийн 13,9-74,1%, өвөрмөц экосистемийн 9–79,3% нь ТХГН-ийн сүлжээнд хамрагдсан байна.

- Монгол орны ойн сангийн талбайн 45 орчим хувь, томоохон гол, мөрний урсац бүрэлдэх эх болон гадаргын усны эзлэх нутаг дэвсгэрийн 10 орчим хувь, устах аюулд орсон болон устаж болзошгүй 300 амьтан, ургамлын үндсэн тархац нутгийн 60 гаруй хувь, байгалийн үзэсгэлэнт газар, байгаль, түүх, соёлын үнэт өв бүхий газар нутгийн 80 гаруй хувийг улсын тусгай хамгаалалтад хамруулснаар байгалийн унаган төрх, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, байгалийн баялагийн нөөцийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

- Эх нутагтаа 100-аад жилийн өмнө устаж үгүй болсон дэлхийн устах аюулд орсон тахь адууг 4 тусгай хамгаалалттай газарт сэргээн нутагшуулснаар тэдгээрийн тоо толгой 575 хүрч, дэлхийд туршлага болохуйц үр дүнтэй ажлыг амжилттай хэрэгжүүлж байна.

### 4. Экосистемийн үйлчилгээ, аялал жуулчлал:

- Тусгай хамгаалалттай газар нутагт аялал, жуулчлалын 360 орчим баазын 80 гаруй хувь нь байршиж, жилдээ ойролцоогоор 400 мянга орчим гадаадын жуулчид, аялагчдыг хүлээн авч, ажлын байр бий болгож, аж ахуйн нэгж байгууллагын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж байна.

### 5. Олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлэлцээрт хамрагдсан байдал:

- Дэлхийн байгаль, соёлын өвд: 2003 онд Увс нуурын ай савын ДЦГ, 2004 онд Орхоны хөндий соёлын дурсгалт газар, 2011 онд Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор, 2015 онд Бурхан Халдун уул тус тус бүртгэгдсэн.

- Дэлхийн Хүн ба шим мандлын нөөц газрын сүлжээнд: 1990 онд Говийн их ДЦГ, 1996 онд Богдхан уулын ДЦГ, 1997 онд Увс нуурын ай савын УТХГ, 2004 онд Хустайн нурууны БЦГ, 2005 онд Дорнод монголын УТХГ, 2007 онд Монгол Дагуурын ДЦГ, 2012 онд Хөвсгөлийн БЦГ /шийдвэр хараахан гараагүй/

- Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц /РАМСАР/-ийн хавсралтад: Монгол дагуурын ДЦГ(1992), Увс нуурын ай сав (1993), Хөвсгөл нуур (1992), Хорго тэрхийн цагаан нуур (1995), Хар ус нуур (1997), Хяргас.Айраг нуур (2000), Онон.Балжийн гол (2000), Булган гол (1995), Яхь нуур (1998), Хүйсийн найман нуур (1992), Ганга нуур (1993) хавсралтад бүртгэгдээд байна.

### Цаашид анхаарах асуудлууд:

1.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн хилийн зааг, менежментийн эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, байгальд ээлтэй аялал жуулчлал, ногоон хөгжлийн түшиц газар болгон хөгжүүлнэ.”зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын хаврын чуулганаар батлуулан мөрдүүлэх;

2.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авна” гэсэн зорилтыг

хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгаль, түүх соёлын үнэт өв болон ховордсон амьтан, ургамлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг сааруулах, дасан зохицох шаардлагыг харгалзан зайлшгүй шаардлагатай газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг үе шаттайгаар УИХ-д оруулж хэлэлцүүлэх;

3.Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежмент санхүүжилтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бусад нэмэлт эх үүсвэрийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар хамгаалалтын менежментийг сайжруулан, ногоон хөгжлийн түшиц газар болгон хөгжүүлэх;

4.Тусгай хамгаалалттай газар нутгуудын менежментийг бүхэлд нь буюу хэсэгчлэн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудад тодорхой нөхцөл болзолтойгоор хариуцуулан улсын төсвийн ачааллыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

## **2. Ус үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**

“Ус” үндэсний хөтөлбөр нь усны асуудлаарх салбар дундын зохицуулалт хийх бодлогын гол баримт бичиг болж байгаа бөгөөд 2015 онд 1 үе шат дууссан тул дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

-Салбарын хэмжээний томоохон хөтөлбөртэй болсоноор энэ чиглэлд хийгдэх гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж, судалгаа шинжилгээний ажлын хүрээ өргөжин тэлж байна.

-Аймгууд “Ус” дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-аараа батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

-Гол мөрний урсац бүрдэх эхийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч байгаа нь усны эхээ хамгаалах, усны нөөцөө цэнгэг байлгах чухал арга хэмжээ болж байна.

-Нийслэл, аймаг, сумдын төвийн ус хангамжийн эх үүсвэр, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийг тогтоож, тэмдэгжүүлдэг боллоо.

-Булаг шандын эхийг хамгаалах, тохижуулах ажлыг хийдэг болсоноор энэ ажлыг хийхэд иргэдийн оролцоо нэмэгдэж, хөдөөгийн хүн амын ундны усны чанар, бэлчээрийн ус хангамж сайжирч байна.

-Үүлэнд зориудаар нөлөөлж байгаа нь хур тунадасны хэмжээг нэмэгдүүлж, га-аас авах ургац, бэлчээрийн хүрэлцээг нэмэгдүүлж, мөнгөн дүнгээр тооцвол үлэмж ашиг оруулж байна.

-Сав газрын захиргаад, орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн усны асуудлаар хамтран ажиллах ажлын уялдаа холбоо сайжирч байна.

-Аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжийн шинэчлэн сайжруулж байгаа нь бохир ус цэвэрлэгээний түвшин нэмэгдэж байна.

-Усны нөөцийг хамгаалахад орон нутаг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулдаг болжээ.

-Хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулж байна.

### ***Дутагдал:***

-Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүйн улмаас төсөл арга хэмжээнүүд цаг хугацаандаа хэрэгжихгүй байна.

-Цас, борооны усыг хуримтлуулах, саарал усыг ашиглах арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.

-Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын зарцуулалт тодорхой бус байна.

-Сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн байгууламж дутагдалтай хэвээр байна.

-Хөрөнгө санхүү их шаардагдах томоохон ажил, мөн усны хайгуул, судалгаа хийж усны нөөцийг тогтоох ажлууд хийгдэхгүй байна.

-Орон нутагт усны мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.

-Жил бүр бэлчээрт олон худаг гаргаж байгаа боловч түүний чанар муу, ашиглалтын байдал хангалтгүй байна.

-Орхон аймгийн хувьд бэлчээрийн ус хангамжийг ХХААГ, усны нөөцийн ашиглалт, хамгаалалтыг БОАЖГ, ус түгээх, нийлүүлэх ажлыг “Эрдэнэт Ус ДТС” ОНӨХК хариуцан

ажиллаж байгаа нь аймгийн хэмжээнд усны нэгдсэн бодлого, удирдлага дутагдаж байгааг харуулж байна.

-Усны орлогод төлөвлөгдөөгүй орлого орсон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын санхүүжилтэд ордоггүй, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хугацаанд нь эрт олгодоггүйгээс зарим ажил (булгийн эхийг хаших г.м.) оройтох тохиолдол гарч байна.

-“Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх II үе шатанд зарим чухал арга хэмжээг оруулаагүй орхигдуулсан байна. Тухайлбал, ХАА (усалгаатай тариалан, бэлчээр усжуулалт)-н ус хангамж, үерийн хамгаалалт, зам, талбайн борооны ус зайлуулах байгууламж, ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмжийг сайжруулах зэрэг асуудлууд тусгагдаагүй байна.

-Салбар хоорондын уялдаа холбоо муугаас мэдээлэл маш дутмаг байна. Аймгуудын УЦУОША-нд хийж байгаа усны судалгаа, шинжилгээ, ажиглалтын мэдээг СГЗ-дад өгдөггүй байна. Усны мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллагууд журмыг хангалтгүй хэрэгжүүлж, мэдээллийг СГЗ-дад ирүүлэхгүй байна.

*Анхаарах асуудал:*

-Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүйн улмаас төсөл арга хэмжээнүүд цаг хугацаандаа хэрэгжихгүй байна. Иймээс санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх,

-Усны нөөцийг хайгуул, судалгааны үндсэнд тогтоох, цас, борооны усыг хуримтлуулах, саарал усыг эргүүлэн ашиглах технологийг нэвтрүүлэх,

-Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд ус хангамж ариутгах татуургын байцаагч ажиллана гэж заасан байдаг ч аймгийн МХГ-т энэ орон тоо байдаггүй учир усыг зүй бусаар ашиглах, ус ихээр алдагдуулах зэрэг зөрчлүүдэд хуулийн дагуу арга хэмжээг тооцуулах арга хэмжээг хэрэгжүүлэх,

-Аймгийн ус хангамж, ариутгах татуургыг хариуцсан байгууллага нь орон нутгийн өмчтэй, улс, орон нутгаас татаас авдаггүй учир тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг цаг тухай бүрт нь хийж чадахгүй байна. Төсөл хөтөлбөр, зээл тусламжаар олон тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж шинэчлэлт хийдэг боловч тоног төхөөрөмж нь хурдан хуучирдаг, зээлийн эргэн төлөлтийг хийж чаддаггүй эргээд олон сая төгрөгийн өглөгтэй болж ашиггүй алдагдалтай ажилладагт анхаарах,

-Стандартын шаардлага хангасан ундны усаар хангагдаж буй хүн амын хувь хэмжээг нэмэгдүүлэх, сумдын ус хангамжийн эх үүсвэрт өргөх станц барих, усны чанарыг сайжруулах,

-Аймгийн төв, нийслэлийн гэр хорооллын ус түгээх цэг болон айл өрхийг цэвэр ус болон бохир усны шугамд холбох ажлыг эрчимжүүлэх,

-Газар тариалан, мал аж ахуйн ус хангамжийг нэмэгдүүлэх,

-Говь нутгийн амин гол хүчин зүйл болсон газрын доорх усыг үйлдвэрлэлийн зориултаар уул уурхайд ашиглахыг багасгах, тоолууржуулах, цэвэршүүлэн эргүүлэн ашиглалтыг нэмэгдүүлэх, Орхон говь төслийг түргэтгэх,

-“Сумын төвийн шинэчлэл” төслийн үр дүн сайн байгаа тул бусад сумдад үргэлжлүүлэх,

-Усны асуудлыг дан ганц төр захиргааны байгууллага хариуцах бус хувийн хэвшил, ААН, компаниуд, иргэд анхааралдаа авч буруу хэрэглээгээ зогсоон гадаргын усаа түлхүү ашиглах хөв цөөрөм, усан сан байгуулах ажлыг өрнүүлэн дэмжих,

-Өмнө нь судлагдаж байсан судалгааны ажлын дүн, тайлан мэдээ СГЗ-дад хангалтгүй, аймгийн УЦОША-д усны чанар, найрлага, нөөц горимын мэдээ мэдээллийг СГЗ-дад ирүүлж байх,

-Сав газрын жижиг голуудад усны ажиглалт хэмжилтийн харуул цөөн байгаа бөгөөд гадаргын усны хэмжилтийн сүлжээг орон зай, цаг хугацааны хувьд нягтруулж, багаж төхөөрөмжийг сайжруулан, чанартай, тасралтгүй ажиглалт хийх нөхцөлийг хангах,

-Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежмент төлөвлөгөө нь батлагдаагүй байгаа сав газруудын усны нөөцийн нэгдсэн менежмент төлөвлөгөөг яаралтай боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх,

-Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд (байгаль орчны асуудал эрхэлсэн төр захиргааны төв болон орон нутгийн байгууллага)-ын ажлын уялдаа холбоог сайжруулах.

-Зам, талбайн борооны ус зайлуулах байгууламж, төмөр замын үерийн усны хамгаалалтын барилга, байгууламжийн эзэмшлийг тодорхой болгох,

-Орхон аймаг нь газар нутгийн байршлаар Орхон-Чулуут голын сав газарт хамаардаг, Сэлэнгэ голын СГЗ Эрдэнэт хотод байршдаг тул тус сав газрын харьяанд хамруулах талаар эрх зүйн орчинг баталгаажуулж өгөх. Аймаг орон нутагт усны талаарх бодлого нэгдмэл бус байгаа тул шаардлагатай бол орон тооны алба нэгж байгуулан ажиллуулж, орон нутгийн удирдлагын түвшинд шийдвэрлэж, эрх зүй эдийн засгийн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

### **3. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**

Тус хөтөлбөрийн 1 үе шат 2016 онд дууссан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд байгаль орчинтой холбоотой асуудлуудад төсөв санхүүжилт хангалтгүй байна. Төсвийн хүндрэлтэй нөхцөлд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажилд анхаарал хандуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөны 1 зорилт болох “уур амьсгалын өөрчлөлтийн улмаас гарч байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх” үйл ажиллагаа нь үндсэндээ биелэлт бүрэн хангагдсан гэж дүгнэж байна.

Хөтөлбөрийн 5 дугаар зорилт болох “олон нийтийг уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдээллийг хүн амд өгөх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаа, арга хэмжээнд идэвхитэй оролцоход нь дэмжлэг үзүүлэх” гэсэн үйл ажиллагаа нь салбар бүрд бүх түвшинд тогтмол хийгдэж үйл ажиллагаа нь жигд явагдаж хэвшсэн байна.

*Цаашид анхаарах асуудал:* Хөтөлбөрийн 2, 3, 4 дүгээр зорилтуудын хүрээнд ажлууд хугацаандаа хэрэгжиж байгаа боловч төсөв хөрөнгийн дутагдалтай талууд их тулгарч байна. Хөтөлбөрийн үйл ажиллагааны эхний шат дуусч, төсөв хөрөнгийн дутагдал, чадавхи бага боловч хөтөлбөрийн 2 шатыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

### **4. Ойн цэвэрлэгээ үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**

Монгол орны ойг цэвэрлэж эрүүлжүүлэх, төлөв байдлыг сайжруулах, түймэр, хөнөөлт шавжийн хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, ойг нөхөн сэргээх, ойн цэвэрлэгээгээр гарсан модоор түлш, ахуйн хэрэгцээний тодорхой хэсгийг хангах, шахмал хавтан, шахмал түлш, барилгын материал болон бусад эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг модон түүхий эдээр хангаж, модны ашиглалтын түвшнийг дээшлүүлэх, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн аж ахуйн нэгжийг чадавхжуулахад ач холбогдолтой хөтөлбөр хэрэгжиж байна гэж үзэж байна. 2014-2016 он буюу 1 үе шатны хэрэгжилтийг дүгнэхэд:

1. Нийт 82,4 мянган га ойн талбай цэвэрлэгдэж, ойн төлөв байдал сайжирсан.
2. Ойн сан бүхий аймгууд ойн цэвэрлэгээр 2066 мянган шоо метр мод бэлтгэж, модны хэрэгцээний тодохой хэсгийг хангасан байна.
3. 82,4 мянган га ойн шатах материалын нөөцийг 2066,3 мянган шоо метрээр тус тус багасган, түймрийн аюулын эрсдэлийг 2 дахин бууруулж, иш холтосны хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлж хамгаалсан.
4. Ойн цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд 6,1 мянган га талбайд ойг нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэсэн.
5. Ойн цэвэрлэгээр 412,5 мянган шоо метр хэрэглээний мод, 1654,1 мянган шоо метр түлээний мод бэлтгэж, түлшний болон хэрэглээний модны тодорхой хэсгийг хангаж, хууль бус мод бэлтгэл эрс буурсан.
6. Ойн цэвэрлэгээгээр бэлтгэгдсэн модон түүхий эдийг боловсруулах, шинэ техник, технологи нэвтрүүлэх, импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын бондын хөрөнгөөс 28,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, олон үйлдвэрүүд технологио шинэчлэхээр ажиллаж байна. Мод боловсруулах чиглэлийн салбарын аж ахуйн нэгжүүд албан бус мэдээгээр 8,0 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгөөр хийсэн байна /Хуучнаар Аж үйлдвэрийн яамны мэдээ/.

7. Мэргэжилтэй ажилтан бэлтгэх түр сургалтыг зохион байгуулж, 38 хүнд мэргэжлийн сертификат олгосон. Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх уулзалт, хэлэлцүүлэг, сургалтыг аймаг, сумын удирдлага, сумын болон сум дундын ойн анги, ойн мэргэжлийн байгууллагын захирал, инженер техникийн ажилчид, ойн нөхөрлөлийн гишүүдийг оролцуулан зохион байгуулж, нийт 1984 хамрагдав.
8. Жилд дунджаар 7 аймгийн 40 сумын 115 ААНБайгууллага, 140 ойн нөхөрлөл, 27 иргэдийн бүлгийн 2517 хүн хөтөлбөрт хамрагдан 804 иргэн түр болон байнгын ажлын байраар хангагдан ажилласан байна.

*Цаашид шийдвэрлүүлэх асуудал:*

1. Ойн цэвэрлэгээний ажлын өртөг, зардал өндөртэй, цэвэрлэх талбайн хэмжээ дэд бүтцээс алслагдсан ойн зам муутай, гүйцэтгэгч байгууллагын чадавхи сул зэрэг шалтгаанаар мод бэлтгэлийн аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлийн оролцоо сул байна. Иймд ойн цэвэрлэгээнд ашиглах техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн асуудлыг нэн түрүүнд шийдвэрлэх,
2. Ойн замын хайгуул хийх, зураг, төсөв боловсруулах, барьж байгуулах, ойн замын сүлжээг өргөжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэх,
3. Ойн цэвэрлэгээгээр бэлтгэгдсэн модон түүхий эдийг боловсруулах шинэ техник, технологи нэвтрүүлж, шахмал хавтан, шахмал түлшний үйлдвэрүүдийг нэн түрүүнд ашиглалтанд оруулах шаардлагатай байна.

**5.Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**

Уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалж, ойн сан хомсдох, цөлжилт, элсний нүүлт, шар шороон шуурга улам эрчимжиж байгаа экологийн өнөөгийн сөрөг нөлөөллийг багасгаж, цөлжилт, элсний нүүлтийг сааруулах, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгоход байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц бодлого, арга хэмжээг бүс нутгийн онцлогт тохируулан урт хугацааны турш үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх үндсэнд Монгол орны говь, хээрийн бүсийн заагийг бүрэн хамарсан ногоон зурвас, ногоон төгөл байгуулахад энэхүү хөтөлбөр ач холбогдолтой юм.

Хөтөлбөрт зааснаар 2005-2015 оны хооронд нийт 40,0 мянган га талбайд ойжуулалт, ойн зурвас, ногоон хэрэмийн ажил гүйцэтгэхээс хөтөлбөр хэрэгжсэний дүнд 9957,2 га талбайд зориудаар ойжуулалт, ойн зурвасын ажил хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл хангалтгүй байгаа нь хөрөнгө, санхүүжилт хангалтгүй байгаатай холбоотой байна. Хэдийгээр эхний үе шатны ажлын гүйцэтгэл бага хувьтай байгаа боловч ойн зурвас байгуулсан зарим газруудад хөрсний элэгдэл, эвдрэл багасаж, тухайн газар нутагт амьдарч байгаа иргэд ашиг шимийг нь хүртэж байна.

Байгалийн задгай ус, усалгаатай хэсгийн ойн зурвасын ургалтын хувь сайн байна. Зарим аймгуудад байгуулсан ойн зурвасаараа өрхийн амжиргааны өртгийг нэмэгдүүлэх, аж ахуй нэгж, байгууллага ашиг олох боломжтой болсон.

*Цаашид анхаарах асуудлууд:*

1. Говь хээрийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудаар биологийн нөхөн сэргээлт хийх, ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг дараагийн үе шатанд өргөн хүрээтэй хэрэгжүүлэх,
2. Говь цөл, хээрийн бүсийн модлог, сөөглөг, өвслөг ургамал, бүх төрлийн амьтадын бүрдэл, тархац, биомасс, усан хангамж, хөрсний бүтэц, уур амьсгалын зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хамарсан экосистемийн иж бүрэн судалгаа явуулж, хөтөлбөр хэрэгжүүлэх аж ахуйн арга хэмжээний шинжлэх ухааны үндэслэлийг нарийвчлан боловсруулах,
3. Ойн зурвасыг байгуулахад хөдөлмөрийг хөнгөвчилсөн орчин үеийн байгальд ээлтэй, шинэ техник технологи, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллах,
4. Ойн зурвас бүхий таримал ойг ойн санд бүртгэж, аж ахуй нэгж, иргэнд урт хугацааны гэрээгээр эзэмшүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх,
5. Бэлчээрийг усжуулах зорилгоор гаргасан уст цэгүүдийг ашиглан мод үржүүлэг, ойн зурвас бий болгох,
6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, техникийн болон

буцалтгүй тусламж, байгууллага аж ахуй нэгжийн хөрөнгө болон бусад эх үүсвэрийг эрс нэмэгдүүлэх,

7. Уст цэггүй хэсгийн үндсэн болон туслах зурвасын байршил газруудад худаг ус гаргах нуур, хөв цөөрөм байгуулах, эрх бүхий байгууллагуудын салбар хоорондын уялдаа холбоог сайжруулан, зохицуулалтыг хангаж ажиллах зэрэг нь хөтөлбөрийн үр дүнг сайжруулахад чухал ач холбогдолтой.

#### **6.Чанарын болон байгаль орчны удирдлага(менежмент)-ыг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**

Улсын хэмжээнд чанарын болон байгаль орчны удирдлагын талаарх нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын тогтолцоог улам төгөлдөржүүлэх зорилготойгоор хэрэгжиж, хэрэгжих хугацаа дуусч байгаа бөгөөд Тус хөтөлбөр 2002-2016 онд 3 үе шаттайгаар хэрэгжихээр төлөвлөгдөн эхний үе шатны 2002-2006 оны төлөвлөгөө батлагдан гарч хэрэгжсэн боловч 2, 3 дахь үе шатны төлөвлөгөөг ЗГХЭГ, ХХААЯ, СХЗГ-тай хамтран боловсруулан хэрэгжүүлэх талаар ЗГХЭГ санал хүргүүлсэн боловч дараагийн үе шатны төлөвлөгөө батлагдан гараагүй.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ХХААХҮЯ/хуучнаар ҮХЯ/ голлох байр суурьтай оролцохоор тогтоолд заасан боловч төрийн байгууллагын ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс хөтөлбөрийн хэрэгжилт дунджаас доогуур үзүүлэлттэй, хангалттай үр дүн гараагүй болно.

Тус яамны Цэвэр технологийн хэлтэс нь 2010 оноос эхлэн уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан ажиллаж байгаа бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бусад байгууллагын хамтын ажиллагаа дутмаг, төсөв хөрөнгөгүйгээс хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэж байна.

#### **7. Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**

*Ололттой тал:* Хог хаягдлын хууль эрхзүйн орчны шинэчлэлт хийгдэж байгаатай холбоотойгоор Хог хаягдлын тухай хууль, журам, ангилалд УЗОБ-той холбоотой зохицуулалтыг тусгаж өгөх бүрэн боломжтой болсон.

*Дутагдалтай тал:* Хөтөлбөр зөвхөн олон улсын байгууллагын тусламж дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа бөгөөд хөрөнгө, санхүүжилт дутагдалтай байна. Оролцогч яам, агентлагуудын ажилтнуудыг сургалтанд хамруулж, мэдлэгийг дээшлүүлэх замаар хөтөлбөрт заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хамтран ажиллах боломжтой боловч хариуцсан мэргэжилтэн нь байнга солигдох, тогтворгүй байх хүндрэл үүсч, удирдлагын дэмжлэг, ойлголт хангалтгүй байна.

#### **8. Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**

Озоны давхаргыг задалдаг бодисын хэрэглээг үе шаттай бууруулж, улмаар бүрмөсөн хязгаарлах, ашиглагдаж буй озон задалдаг бодис (ОЗБ)-ыг озоны давхаргыг үл задлах бодисоор орлуулахад хөтөлбөрийн зорилго орших бөгөөд үндэсний хөтөлбөр нь Венийн Конвенци, Монреалийн Протокол (МП)-оор Монгол улсын хүлээсэн үүргийг биелүүлэхэд бүрэн чиглэгдэнэ. Дараах дүгнэлтийг томъёолбол:

1. БОНХАЖ-ын Сайдын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А-429 тоот тушаалаар батлагдсан тоо хэмжээ, квотын дагуу ОЗБ болон орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжинд зөвшөөрөл олгон хяналт тавин ажиллаж, ОЗБ-ын импортыг шат дараалан бууруулах ажлыг амжилттай гүйцэтгэж байна.
2. Дэлхийн дулааралд нөлөөтэй HCFC төрлийн бодисыг 2013 онд суурь түвшинд, 2015 он гэхэд 10, 2020 онд 35 хувиар тус тус үе шаттай бууруулж, 2030 он гэхэд импорт, хэрэглээг бүрмөсөн зогсоох олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор HPMP хөтөлбөрийг графикт хугацаа баримтлан амжилттай хэрэгжүүлж байна.
3. Гаалийн байгууллагатай нягт хамтран ажиллаж байнгын мэдээ, мэдээлэл солилцож, хамтын ажиллагаагаа бэхжүүлж байна.
4. Хяналтын зөвшөөрлийн тогтолцоог мөрдөн ажиллаж, сургалт семинар зохион байгуулсаны үр дүнд озоны давхаргад ээлтэй хөргөлтийн төхөөрөмж, орлуулах бодисын импорт, хэрэглээ байнга өсөн нэмэгдэж, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэдэг компаниуд шинэ технологи нэвтрүүлж байна.

5. ОЗБ бүхий тоног төхөөрөмж импортлох хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдэд ОЗБ, тэдгээрийн хор хөнөөл, озоны давхаргын хомсдлын байгаль болоод хүний эрүүл мэндэд нөлөөлөх хор хөнөөлийг тайлбарлах, ОЗБ-ыг орлуулах бодис бүхий тоног төхөөрөмж импортлохыг ухуулан таниулах мэдээлэл сурталчилгааны ажил өргөн хүрээтэй явуулж байна.
6. Озоны давхаргын нимгэрэл болон уур амьсгалын өөрчлөлтийн уялдаа холбоо, ОЗБ-ын хор хөнөөл, озоны давхарга, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөгүй шинээр нэвтэрч буй тоног төхөөрөмж, технологийн талаар мэдээлэл сурталчилгааны ажлууд, хурал, сургалтуудыг зохион байгуулав.
7. Озоны давхарга ба түүний үүрэг, нөлөө, озоны давхарга цоорсноос хүний эрүүл мэнд, ургамал, амьтан, байгальд учруулах хор уршиг, байгаль орчинд ээлтэй шинэ техник технологийг сонгох зөвлөмж, мэдээллийн фото стикер самбарууд, гарын авлага, брошур гэх мэт олон нийтэд зориулсан тараах материалуудыг хэвлүүлэв.
8. Тайлан мэдээг цаг тухайд нь холбогдох яам, байгууллага, олон улсын байгууллагуудад тайлагнаж байна.
9. ЗГ-ын 1999 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Озон задалдаг бодисыг импортлох, ашиглах, худалдах тусгай зөвшөөрөл олгох журмыг” шинэчлэн боловсруулж, 2016 оны 3 дугаар сард 4 дэх удаагаа ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.

*Дутагдал, анхаарах асуудлууд:*

1. Монгол улсын Агаарын тухай хуулийн 25.1-д заасаныг хэрэгжүүлэх зорилгоор 2012 онд Озон задлах бодисын импортын талаар нэмэлт өөрчлөлт оруулан сайжруулан боловсруулж, бэлэн болгож шинэчилсэн журамыг ЗГ-т өргөн барьсан боловч одоо болтол батлагдахгүй байгаа нь зөвшөөрөл олгох үйл явц болон иргэд, ААН-дэд хүндрэл учруулж байна.
2. Хөргөлтийн техникийн инженер, техникийн ажилтнуудын зөв зохистой засвар үйлчилгээ хийх чадавхийг үнэлэх стандарт боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ талаар стандартын төсөл боловсруулж зохих газруудаас санал авч байна.
3. ОЗБ-ыг орлуулах бодис бүхий шинэ технологиуд нэвтэрч байгаа ч Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний мэргэжлийн байгууллагуудын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг батлахдаа ОЗБ бүхий технологи ашигласан аливаа төсөл, тайланг батлахгүй байх, үнэлгээний компаниуд ОЗБ-ыг орлуулах шинэ төрлийн бодис бүхий технологийг үнэлгээ захиалагч нартаа санал болгох бодлогыг яамны зүгээс хатуу баримтлах шаардлагатай байна.

**9. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**

Хөтөлбөрт нийтдээ 78 үндсэн арга хэмжээ тусгагдсан байна. Эдгээр арга хэмжээнүүдийн 40 нь сайн, 32 нь дунд, 6 нь хангалтгүй хэрэгжсэн байна.

*Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарсан ололттой зүйлс:*

- Хууль эрх зүйн орчин шинэчлэгдэж боловсронгуй болсон.
- Холбогдох яамд, агентлагууд, аймгууд Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хийсэн ажлаа тайлагнаж хэвшсэн.
- Аймгууд дэд хөтөлбөр, төлөвлөгөөтэй болж ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж эхэлснээр орон нутгийн түвшинд хийгдэж буй бодит ажлын хэмжээ нэмэгдэж байна.
- Олон нийтэд цөлжилтийн үр дагаварын талаарх мэдээлэлийг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр өгснөөр цөлжилтийн шалтгаан, нөхцөл, хор уршгийн талаар олон нийтийн ойлголт нэмэгдэх нөхцөл бий болсон.
- Цөлжилт, түүний шалтгаан нөхцлүүд болон бусад мэдээлэлүүдийг багтаасан мэдээлэлийн цахим сан бий болгон тогтмол ажиллуулж байна.
- Дунд сургуулийн хөтөлбөрт байгаль орчин, цөлжилтийн хор уршгийн талаар тусган хүүхэд залуучуудад мэдээлэл олгож эхэлсэн.
- Цөлжилттэй тэмцэх технологи, арга барилын талаарх мэдээлэлийн цахим хуудас олон нийтэд нээлттэй ажиллаж байна.
- Цаг уурын өртөө, харуулуудыг шаардлагатай багаж хэрэгслээр хангаж бэхжүүлснээр улсын хэмжээнд байгалийн бүс, газар зүйн байршлын хувьд сум, багийн түвшинд цөлжилтийн хяналт, шинжилгээг хийх боломж бүрдсэн.



- Улс орны хэмжээний цөлжилтийн төлөв байдлын зураглалыг олон улсын аргачлалын дагуу хийж үндэсний атласыг гаргасан.

*Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл:*

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын зохицуулалт шаардлагын түвшинд хийгдэхгүй байна.
- Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтээр тодорхой ажил хийгдэж байгаа боловч цөлжилттэй тэмцэх талаар амжилттай ажиллаж буй гадаад орнуудын туршлагатай танилцуулах санхүүжилт дутагдалтай байна.
- Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг санхүү, хөрөнгийн талаарх бодлогын арга хэмжээ дутагдалтай байна.
- Хөрөнгө санхүүжилт дутагдалтай, хүрэлцээгүй байдгаас Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг бүрэн хэмжээнд хэрэгжүүлж чадахгүй байна.
- Цөлжилттэй тэмцэх ажлыг улсын хэмжээнд удирдан чиглүүлж зохицуулах үүрэгтэй Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны ажлын албыг татан буулгасан нь хөтөлбөрийн хэрэгжилтэнд нөлөөлж байна.

*Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс:*

- Цөлжилт, газрын доройтолд өртөж буй бүс нутгийн холбогдох судалгааг хөрөнгө гарган хийх,
- Аймгуудын цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах ажлыг зохион байгуулах
- Салбар дундын ажлын уялдаа зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

#### **10. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**

Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхлээд удаагүй боловч үр дүнтэй ажил болж байгааг тэмдэглэж байна.

*Ололттой тал:* Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдснаар уг хөтөлбөр хэрэгжих хууль эрхзүйн орчин бүрдэнэ.

*Дутагдалтай тал:* Хөрөнгө, санхүүжилт хангалтгүй, дутагдалтай бөгөөд хог хаягдал цуглуулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалт байхгүйгээс энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд бий болдоггүй, цөөхөн байгаа үйлдвэрүүд нь түүхий эдийн хангалтгүй, дэмжлэг хөнгөлөлтгүйгээс тогтвортой ажиллаж чаддаггүй байна.

Үндэсний хөтөлбөр 2014 оны 9-р сарын 18-нд, Үйл ажиллагааны төлөвлөгөө 2015 оны 12-р сарын 24-ны өдөр батлагдсан. 2016 онд Хог хаягдлын хуулийг шинэчлэн найруулж, УИХ-аар батлагдсан боловч ёсчлогдоогүй учраас дахин УИХ-аар хэлэлцэгдэж байна. Шинэ хуулийн төсөл нь өмнөх хуулиас зорилго, хамрах хүрээ, зохицуулалтын хувьд өөрчлөгдсөн тул уг хуультай нийцүүлж Үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг дахин шинэчлэх шаардлагатай юм..

#### **11. Хатан-Туул үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**

Хатан Туул хөтөлбөрийн 1 үе хэрэгжиж дуусч байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн талаарх, төрийн бодлогын зорилтууд хэрэгжиж, үр дүнгээ өгч эхэлсэн, Туул голын усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх, бохирдлыг бууруулах чиглэлээр дунд хугацаанд боломжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, ус хангамжийг хэвийн байлгах, нөөцийн зохистой ашиглалт бий болгох, бохирдлыг хүлцэх хэмжээнд хүртэл цэвэршүүлэх замаар Туул голын сав газарт оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг ханган баталгаажуулахад төрийн байгууллагын хамтын ажиллагаа, төсөв хөрөнгийн эх үүсвэрийн эхлэл суурь тавигдсан гэж үзэж байна.

*Цаашид анхаарах асуудлууд:* Хатан туул хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтын асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна. Томоохон төслүүд нь хөрөнгө санхүүжилтгүйн улмаас олон жил зогсонги байдалд байна. Тухайлбал: Туул усан цогцолбор, Туул-Сонгино усан цэнэгт цахилгаан станц, Төв цэвэрлэх байгууламжийн өргөтгөл шинэчлэл, Арьс шир боловсруулах үйлдвэрийг хотоос гаргах, Туул голын бохирдлыг бууруулах, усны нөөцийг нэмэгдүүлэх, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх гэх мэт. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, салбар дундын зохицуулалт хийх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган улсын төсөв

болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авах талаар даалгасан боловч төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагаа хангалтгүй байна.

#### **12. “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд:**

Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэн нэн ховор, ховор амьтны нөөцийн хомсдолыг хязгаарлан зогсоож, тэдгээрийг байгалийн жамаар хэвийн өсөж үржих нөхцөлийг хангах, зориудаар үржүүлж, цөм сүргийг хамгаалах замаар тэдгээрийн тоо толгойг нэмэгдүүлэн тогтвортой ашиглах бодлогын чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгууллага, аж ахуйн нэгж, иргэд хамгийн ихээр дэмжиж, олон талт арга хэмжээг зохион байгуулан хамтран ажиллаж, дэмжлэг тусалцаа үзүүлж байна. Мөн улсын төсвөөр нэн ховор амьтдыг судлах, сурталчлах чиглэлээр төсөв хөрөнгийг бололцоотой хэмжээгээр санхүүжүүлж байв. Бүх аймгуудын Байгаль орчны газар, Тусгай хамгаалалтын нутгийн захиргаад болон ШУА-ийн хүрээлэнгүүд, МУИС зэрэг маш идэвхтэй хамтран ажиллав.

*Дутагдалтай тал:* Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай томоохон хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин хангалтгүй байна. Тухайлбал: аж ахуйн ач холбогдол багатай нэн ховор амьтныг /хүдэр, бөхөн, тул загас г.м/ өсгөн үржүүлэх аж ахуй байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалт байхгүй дутагдал байна.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монголын амьтан, ургамлыг хамгаалах үндэсний хороог байгуулсан боловч орон тоо, төсөв батлагдаагүйгээс 2015 онд яамны бүтцийн нэгжийн мэргэжилтэн үргэлжлүүлэн давхар хариуцан ажиллав.

#### **13. “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд:**

Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн, суурийг тавьсан анхны жил байсан бөгөөд гадаад хамтын ажиллагааны хүрээнд Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран Улаанбаатар хотноо Нүүдлийн аялал жуулчлал ба хотуудын тогтвортой хөгжил олон улсын хурлыг зохион байгуулсан, БНХАУ-тай аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэн байгуулсан, Цайны зам аялал жуулчлалын брэндийг хөгжүүлэх зорилгоор Монгол, ОХУ, БНХАУ-ын Аялал жуулчлалын сайд нарын анхдугаар уулзалт БНХАУ-ын Хөх хотноо зохиогдож, Цайны замын олон улсын холбоо байгуулах тунхаг бичигт гарын үсэг зурсан зэрэг ололт, амжилттай байв.

*Анхаарах асуудал, дутагдалтай тал:* 2016 оны 9-12 дугаар сарын санхүүжилтийг татсанаас шалтгаалан төлөвлөгөөнд тусгагдсан олон ажил санхүүжилтгүйн улмаас хийгдээгүй. Дэд бүтцийг сайжруулах, бүтээн байгуулалтын ажилд санхүүжилт нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

#### **14. “Биологийн олон янз байдлын тухай үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд:**

“Биологийн олон янз байдлын тухай” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд 2016 оны жилийн эцсийн байдлаар “үнэлэх боломжгүй” дүгнэсэн болно. Тус үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүйгээс хөтөлбөрийн биелэлтийн тайлан гаргаагүй тул дүгнэх боломжгүй гэж дүгнэв.

#### ***Тав. Дүгнэлт***

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлэх 2016 оны жилийн эцсийн байдлаар УИХ-ын тогтоолоор батлагдсан 3, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 11, нийт 14 үндэсний хөтөлбөрийг хяналтад авч, хэрэгжилтийн гүйцэтгэлд үнэлгээ өгөв.

2016 оны жилийн эцсийн байдлаар ерөнхий гүйцэтгэл **76.8 хувьтай** буюу 3.84 оноотой дүгнэгдэж, 1 хөтөлбөр 100% буюу бүрэн хэрэгжсэн, 5 хөтөлбөр 90 хувьтай, 5 хөтөлбөр 70 хувьтай, 2 хөтөлбөр 50 хувийн биелэлттэй, 1 хөтөлбөр үнэлэх боломжгүй буюу үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулахад **0.8 хувийн өсөлттэй** дүгнэгдэв. Үнэлгээний дүнг хавсралт 1-д харуулав.

Улсын төсөв, хөрөнгө санхүүгийн хүндрэлээс шалтгаалан зарим ажил удаашралтай, хэрэгжилт хангалтгүй байсан ч олон улсын байгууллагын тусламж, дэмжлэгээр хөтөлбөрийн хэрэгжилтэд ахиц гарсан, өссөн дүнтэйгээр дүгнэгдлээ.

### **Зургаа. Зөвлөмж**

Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоолоор байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлэхээр тусгагдсан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, зорилт үр дүнг хүрэх түвшинтэй уялдуулан хэрэгжилтийг ханган, гүйцэтгэлд анхаарч, тодорхой үр дүнд хүрч байгаа ч цаашид анхаарах шаардлагатай санал, зөвлөмжүүдийг томъёолбол:

1. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат бүрийн төлөвлөгөө, тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд суурь үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлон батлуулж, мөрдөж хэвших,

2. Тухайн жилийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг тодорхой тоон үзүүлэлт, баримтад тулгаарлан үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нөхцлийг бүрдүүлэх, тайлагнахад онцгойлон анхаарах,

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад холбогдох нэгж, газрууд байнгын дотоод хяналт тавьж ажиллах,

4. Хөтөлбөрийн санхүүгийн зарцуулалтын явцад нэгж, газрууд хяналт тавьж, хөтөлбөрийн үр дүн, ач холбогдолыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллах,

5. Зарим улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлууд санхүүгийн хүндрэлээс шалтгаалан тасарч, удааширч байгааг анхаарч, цаашид төлөвлөлтөд онцгойлон анхаарах, үнэлгээний аргачлалыг бодитоор тооцох,

6. Хөтөлбөрийг шинээр батлуулахад шинжлэх ухааны үндэслэлтэй, тооцоо судалгаатай, тухайн цаг үеийн болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлтэй үр дүнд суурилсан, биелэгдэхүйц, тодорхой үр дүн гарахуйц, ач холбогдолтой байх шаардлагатай бөгөөд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, зөв, оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх,

7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг үндэслэл, судалгаатай урьдчилан зөв тооцож, бүх шатны буюу орон нутаг, хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд тухайн жилийн төсөвт зайлшгүй тусгах, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх ажлыг үүрэг болгох,

8. УИХ-аар болон ЗГ-ын тогтоолоор батлагдсан нийт үндэсний хөтөлбөрүүдийн улсын хэмжээний нэгдсэн үнэлгээ тайланг дүгнэх, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, олон нийтэд үр дүнг ил тод тайлагнах, үндэсний хөтөлбөрийн талаар мэдээлэл сурталчилгааг явуулах, иргэдэд сурталчлан таниулах, тэдгээрийн үүрэг оролцоо бүхий хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, бүх түвшинд мэдээллийн үнэн бодит байдлыг хангасан, тоон мэдээллийг чанарын түвшингээр баталгаажуулсан байх,

9. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тайлагнах асуудлаар бусад яамд, агентлагууд, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар зэрэг бүх шатны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, хөтөлбөрийн үр дүнд нөлөөлөх, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хуулийн хугацаанд тайлагнаж хэвшихэд онцгойлон анхаарах,

10. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын орон нутаг дах харьяа байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөс хамааран аймаг, нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг салбарын бодлого, эрх зүйн хүрээнд ажиллаж, салбарын менежментийг сайжруулахад анхаарал хандуулах, судалгаа, мэдлэг, мэдээллийн шинэ арга зүйг эзэмшүүлэх, бодлогын баримт бичгийг төлөвлөх, тайлагнах, дүгнүүлэхэд онцгойлон анхаарч, хүний нөөцийн зөв, оновчтой бодлогыг хэрэгжүүлэх,

11. Хэрэгжиж дууссан хөтөлбөрийн үр дүнг бататгах, цаашдын тогтвортой үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хангах, үр дүнгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан зэргээс хамааран зарим хөтөлбөрийг хяналтаас хасч үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хамтран хэрэгжүүлэх яам, агентлаг, байгууллага, орон нутаг хамтран ажиллах, өргөжүүлэн хөгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХЭРЭГГИЖ БУЙ  
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**  
(2016 оны жилийн эцсийн байдлаар)

*Хавсралт 1*

№	Актын дугаар	Хөтөлбөрийн нэрс	Хэрэгжих хугацаа	Хэрэгжилтийн явц, хувиар
<b>УИХ-ЫН ТОГТООЛООР БАТАЛСАН</b>				
1	1998/29	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр	2005-2015 1998-2005	96.0
2	2010/24	Ус үндэсний хөтөлбөр	2010-2015 2016-2021	83.8
3	2011/02	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр	2011-2021	92.0
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛООР БАТАЛСАН</b>				
4	2010/90	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр	2010-2020	93.0
5	2005/44	Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр	2005-2035	62.5
6	2014/30	Ойн цэвэрлэгээ үндэсний хөтөлбөр	2014-2016 2016-2020	55.0
7	2014/341 2006/99	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр	2006-2020 2020-2040	78.0
8	1999/129	Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр	1999-2030	100.0
9	2011/277	Нэн ховор, ховор амьтныг хамгаалах үндэсний хөтөлбөр	2012-2021	82.0
10	2002/146	Чанарын болон байгаль орчны удирдлага менежментийг дэмжих үндэсний хөтөлбөр	2002-2016	65.6
11	2012/203	Хатан туул үндэсний хөтөлбөр	2012-2020	70.0
12	2015/298	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр	2014-2017 2018-2022	64.0
13	2015/324	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	2016-2020 2021-2025	56.6
14	2015/325	Биологийн олон янз байдлын тухай үндэсний хөтөлбөр	2016-2018 2019-2021 2022-2025	Үнэлэх боломжгүй
<b>Дундаж үнэлгээ</b>				<b>76.8%</b>
<b>Оноо</b>				<b>3.84</b>

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР